

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
3. Аудитын тайлан	13
3.1. Ерөнхий зүйл	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	14
3.4. Материаллаг байдал.....	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	16
3.7. Шилэн дансны мэдээлэл	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.9. Аудитын илрүүлэлт	18
Залруулсан алдаа.....	
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	19
Аудитын зөвлөмж	19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	19
4. Менежментийн захидал.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	24



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ П.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

2021.02.25 № 07/585
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын хүрээлэнгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Боловсролын хүрээлэнгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Аудитын хүрээнд бусад асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно. Тайлант жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 95 хувиар биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>14,870,630.00</u>	<u>512,880,392.69</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
33	АВЛАГА	5,200,000.00	502,639,362.69
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	2,047,249.20
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		
33300	Татаас, санхүүжилтийн авлага	5,200,000.00	500,592,113.49
35.	БАРАА МАТЕРИАЛ	9,670,630.00	10,241,030.00
35100	Түүхий эд материал	-	-
35400	Хангамжийн материал	9,670,630.00	10,241,030.00
35410	Бичиг хэргийн материал		
35420	Аж ахуйн материал	4,731,430.00	4,731,430.00
35430	Сэлбэг хэрэгсэл		
35440	Түлш, шатах тослох материал	-	260,000.00
35450	Барилгын засварын материал		
35460	Хүнсний материал		
35470	Бусад хангамжийн материал	4,939,200.00	5,249,600.00
35500	Биологийн хөрөнгө		
2.	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>268,097,030.48</u>	<u>335,536,849.15</u>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	268,097,030.48	335,536,849.15
39100	Газар		
39200	Биет хөрөнгө	264,097,030.44	331,066,849.07
39201	Барилга, байгууламж, орон сууц		
39202	Хуримтлагдсан элэгдэл		
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,500,000.00	69,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(11,583,333.36)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	304,151,847.00	286,003,847.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(179,804,436.20)	(83,197,780.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	110,512,042.00	120,597,762.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(40,262,422.36)	(50,253,646.23)
39300	Биет бус хөрөнгө	4,000,000.04	4,470,000.08
39301	Программ хангамж	1,000,000.00	1,470,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,000,000.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	5,000,000.00	5,000,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(999,999.96)	(1,999,999.92)
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	-
300	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>282,967,660.48</u>	<u>848,417,241.84</u>
400	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	0.00
4100	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	0.00
500	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>282,967,660.48</u>	<u>848,417,241.84</u>
5100	Засгийн газрын хувь оролцоо	282,967,660.48	848,417,241.84
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
		96,015,446.35	96,015,446.35
51101	Өмч: - төрийн	96,015,446.35	96,015,446.35
512	Хуримтлагдсан үр дүн	186,952,214.13	752,401,795.49

51210	Өмнөх үеийн үр дүн	212,776,453.01	186,952,214.13
51220	Тайлант үеийн үр дүн	(25,824,238.88)	565,449,581.36
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>282,967,660.48</u>	<u>848,417,241.84</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,818,443,936.00	3,651,094,078.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	117,664,890.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	117,664,890.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	117,664,890.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,385,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	114,279,890.00
121	Хөрөнгийн орлого	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,818,443,936.00	3,533,429,188.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,145,734,000.00	1,289,701,160.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,145,734,000.00	1,289,701,160.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	672,709,936.00	2,243,728,028.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	37,532,336.00	973,898,550.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	460,312,750.00	1,000,842,102.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	174,864,850.00	268,987,376.00
131106	Төсвийн урамшуулал		
2.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,844,268,174.88	3,085,644,496.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,844,268,174.88	3,085,644,496.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,833,034,141.63	2,945,879,149.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	654,901,200.00	979,592,725.27
210101	Үндсэн цалин	517,939,000.00	758,029,721.27
210102	Нэмэгдэл	100,090,000.00	183,814,671.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,872,200.00	36,748,333.00
210104	Урамшуулал		
210105	Гэрээт ажлын хөлс	-	1,000,000.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,416,451.81	124,087,762.97
210201	Тэтгэврийн даатгал	58,645,251.81	91,839,662.97
210202	Тэтгэмжийн даатгал	5,914,600.00	8,062,000.00
210203	Үйлдвэрийн осол, мэргэжилээс шалтгаалах өвчний даатгал	4,337,300.00	6,449,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	690,200.00	1,612,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,829,100.00	16,124,100.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	202,000.00	-
210304	Байрны түрээс	202,000.00	-
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	Хангамж, бараа материалын зардал	44,400,427.17	62,605,453.30
210401	Бичиг хэрэг	29,698,176.00	23,406,275.00
210402	Тээвэр, шатахуун	-	2,560,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,860,621.17	10,898,899.30
210404	Ном, хэвлэл	1,529,130.00	19,933,110.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,312,500.00	5,807,169.00
2105.00	Нормативт зардал	-	21,972,880.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс	-	21,972,880.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2107.00	Томилолт, зочны зардал	49,446,800.00	2,273,284.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	49,446,800.00	2,273,284.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	643,993,807.77	1,012,224,991.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	643,993,807.77	1,005,224,991.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	7,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	358,673,454.88	743,122,052.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	312,184,277.00	673,002,981.51
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,489,177.88	70,119,071.33
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,234,033.25	139,765,347.26
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,300,000.00	87,422,378.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	83,612,378.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,300,000.00	3,810,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,934,033.25	52,342,969.26
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,068,854.25	20,228,782.26
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	865,179.00	32,114,187.00
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
226001	Гадаад эх үүсвэрээр		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(25,824,238.88)	565,449,581.36
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
4.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(25,824,238.88)	565,449,581.36

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,921,116,107.00	3,542,014,188.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	3,385,000.00
110	Орлогын албан татвар	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	3,385,000.00
1200	Нийтлэг татварын бус орлого	-	3,385,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	3,385,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,385,000.00
141001	Гадаадын санхүүгийн зээлийн эх үүсвэр		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,921,116,107.00	3,538,629,188.00
13100	Улсын төвлөрсөн төсвөөс	1,145,734,000.00	1,289,701,160.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,145,734,000.00	1,289,701,160.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	775,382,107.00	2,248,928,028.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	37,532,336.00	973,898,550.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	460,312,750.00	1,000,842,102.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	277,537,021.00	274,187,376.00
131106	Төсвийн урамшуулал		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,776,885,297.00	3,518,735,188.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,776,885,297.00	3,518,735,188.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,760,451,263.75	2,878,377,727.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	654,901,200.00	981,639,974.47
210101	Үндсэн цалин	517,939,000.00	760,076,970.47
210102	Нэмэгдэл	100,090,000.00	183,814,671.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,872,200.00	36,748,333.00
210104	Урамшуулал		
210105	Гэрээт ажлын хөлс	-	1,000,000.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,416,451.81	124,087,762.97
210201	Тэтгэврийн даатгал	58,645,251.81	91,839,662.97
210202	Тэтгэмжийн даатгал	5,914,600.00	8,062,000.00
210203	Үйлдвэрийн осол, мэргэжилээс шалтгаалах өвчний даатгал	4,337,300.00	6,449,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	690,200.00	1,612,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,829,100.00	16,124,100.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	202,000.00	-
210304	Байрны түрээс	202,000.00	-
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	Хангамж, бараа материалын зардал	43,103,427.17	63,175,853.30
210401	Бичиг хэрэг	28,401,176.00	23,406,275.00
210402	Тээвэр, шатахуун	-	2,820,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,860,621.17	10,898,899.30
210404	Ном, хэвлэл	1,529,130.00	19,933,110.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,312,500.00	6,117,569.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	-	21,972,880.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс	-	21,972,880.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,660,900.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,660,900.00	-
2107	Томилолт, зочны зардал	46,289,200.00	2,273,284.00
210701	Гадаад албан томилолт		

210702	Дотоод албан томилолт	46,289,200.00	2,273,284.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	620,893,807.77	1,012,224,991.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	620,893,807.77	1,005,224,991.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	7,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	311,984,277.00	673,002,981.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	311,984,277.00	673,002,981.51
213.00	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,434,033.25	640,357,460.75
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,300,000.00	87,422,378.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	83,612,378.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,300,000.00	3,810,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,134,033.25	552,935,082.75
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	-
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,068,854.25	20,228,782.26
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	6,065,179.00	532,706,300.49
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	144,230,810.00	23,279,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5.	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	144,230,810.00	23,279,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	144,230,810.00	23,279,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	144,230,810.00	23,279,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	144,230,810.00	23,279,000.00
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
226001	Гадаад эх үүсвэрээр		
6.	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(144,230,810.00)	(23,279,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7.	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8.	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10.	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр/						
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцоо нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	96,015,446.35	-	212,776,453.01	-	308,791,899.36
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	96,015,446.35	-	212,776,453.01	-	308,791,899.36
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(25,824,238.88)	-	(25,824,238.88)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	96,015,446.35	-	186,952,214.13	-	282,967,660.48
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	96,015,446.35	-	186,952,214.13	-	282,967,660.48
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	565,449,581.36	-	565,449,581.36
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	96,015,446.35	-	752,401,795.49	-	848,417,241.84

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,343,129,800.00	1,272,857,377.74	70,272,422.26	94.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,343,129,800.00	1,272,857,377.74	70,272,422.26	94.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,250,601,600.00	1,185,434,999.74	65,166,600.26	94.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	852,139,200.00	850,598,497.47	1,540,702.53	99.82
210101	Үндсэн цалин	630,438,300.00	629,035,493.47	1,402,806.53	99.78
210102	Нэмэгдэл	183,828,700.00	183,814,671.00	14,029.00	99.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,872,200.00	36,748,333.00	123,867.00	99.66
210104	Урамшуулал			-	
210105	Гэрээт ажлын хөлс	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,575,300.00	108,471,673.97	103,626.03	99.90
210201	Тэтгэврийн даатгал	76,327,200.00	76,223,573.97	103,626.03	99.86
210202	Тэтгэмжийн даатгал	8,062,000.00	8,062,000.00	-	100.00

210203	Үйлдвэрлэлийн осол, мэргэжилээс шалтгаалах өвчний даатгал	6,449,600.00	6,449,600.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,612,400.00	1,612,400.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,124,100.00	16,124,100.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	392,000.00	-	392,000.00	-
210304	Байрны түрээс	392,000.00	-	392,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	31,632,500.00	29,665,199.30	1,967,300.70	93.78
210401	Бичиг хэрэг	13,198,100.00	11,563,500.00	1,634,600.00	87.61
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	1,900,000.00	100,000.00	95.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,898,900.00	10,898,899.30	0.70	100.00
210404	Ном, хэвлэл	1,037,600.00	1,037,110.00	490.00	99.95
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал			-	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,497,900.00	4,265,690.00	232,210.00	94.84
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал			-	
2105	Нормативт зардал	-	-	-	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,800,000.00	-	2,800,000.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,800,000.00	-	2,800,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	241,257,600.00	187,394,084.00	53,863,516.00	77.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	233,257,600.00	180,394,084.00	52,863,516.00	77.34
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,000,000.00	7,000,000.00	1,000,000.00	87.50
210900	Бараа үйлчилгээний бусад зардал	13,805,000.00	9,305,545.00	4,499,455.00	67.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал			-	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,805,000.00	9,305,545.00	4,499,455.00	67.41
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,528,200.00	87,422,378.00	5,105,822.00	94.48
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-	-	
2132	Бусад урсгал шилжүүлэг	92,528,200.00	87,422,378.00	5,105,822.00	94.48
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	88,715,200.00	83,612,378.00	5,102,822.00	94.25
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,813,000.00	3,810,000.00	3,000.00	99.92
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,343,129,800.00	1,272,857,377.74	70,272,422.26	94.77

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,339,129,800.00	1,269,472,377.74	69,657,422.26	94.80
13100	Улсын төсвөөс санхүүжих	1,339,129,800.00	1,269,472,377.74	69,657,422.26	94.80
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,000,000.00	3,385,000.00	615,000.00	84.63
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,000,000.00	3,385,000.00	615,000.00	84.63
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	51	51	-	
620001	Удирдах ажилтан	1	1	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	49	49	-	
620003	Үйлчлэх ажилтан	1	1	-	

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,248,928,028.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,248,928,028.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,716,221,727.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		131,041,477.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		15,616,089.00
210201	Тэтгэврийн даатгал		15,616,089.00
2104	Хангамж, бараа материалын зардал		37,790,654.00
210401	Бичиг хэрэг		11,842,775.00
210402	Тээвэр шатахуун		920,000.00
210404	Ном, хэвлэл		18,896,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		6,131,879.00
2105	Нормативт зардал		21,972,880.00
210502	Хоол		21,972,880.00
2106	Эд хогшил, урсгал засврын зардал		17,529,000.00
2107	Томилолт, зочны зардал		2,273,284.00
210702	Дотоод албан томилолт		2,273,284.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		824,830,907.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		824,830,907.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		665,167,436.51
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		665,167,436.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		532,706,300.49
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		532,706,300.49
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		532,706,300.49
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		2,248,928,028.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,248,928,028.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		2,248,928,028.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		973,898,550.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,000,842,102.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		274,187,376.00

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Боловсролын хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг П.Лхагвасүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах, үндсэн үйл ажиллагаанаас орох орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах, жолоочийн замын хуудсаар шатахууны тооцоог бодож хэвших, нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооллыг шалгаж, дотоод хяналт, санхүүгийн хариуцлагыг сайжруулан ажиллах, дутуу тайлагнасан цалинг нөхөн тайлагнах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 06-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд “Цэгцтөв Богд Аудит” ХХК-ийн Ахлах аудитор Н.Цэрэнханд, Чанарын хяналтын менежер Д.Өлзий-Орших, аудитор Г.Цэцэгмаа, туслах аудитор Б.Баярмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Боловсролын хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Цэгцтөв Богд Аудит” ХХК-д 2021 оны 01 сарын 22-ний өдрийн 18 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Боловсролын хүрээлэнгийн эрхэм зорилго нь “боловсролын судалгаагаар олон улсын түвшинд хүрсэн эрдэм шинжилгээ, арга зүйн тэргүүлэгч байгууллага болох”-д оршино.

Боловсролын хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Боловсролын бодлого, шийдвэр боловсруулахад судалгааны мэдээллээр хангах.
- Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын асуудлаар байнгын судалгаа, шинжилгээ, туршлага, арга зүй, сургалтын ажлыг эрхлэх.
- Орон нутгийн боловсролын байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.
- Бүх шатны боловсролын байгууллагад сургалт, судалгаа, арга зүйн мэргэжлийн дэмжлэг үзүүлэх.
- Боловсролын хөгжлийн асуудлаар шинжлэх ухааны суурь болон хавсарга судалгаа явуулах.
- Иргэд, олон нийтэд шинжилгээний мэдээллээр үйлчлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Боловсролын хүрээлэн нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг судалж үзэхэд тус байгууллага нь БШУС-ын 2017 оны А/40 тоот тушаалаар нягтлан

бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ батлан мөрдөн ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ шинэчлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Боловсрол шинжлэх ухааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд харьяа орон нутаг дахь Боловсролын хүрээлэнгийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Боловсролын хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны 3 улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,157,263.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 43,145.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурийг хэвээр авч 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,085,644.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 61,672.9 мянган төгрөгөөр тооцон авлаа.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Боловсролын хүрээлэнгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 565,449.5 мянган төгрөгөөр буюу 33.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, бараа материал, цэвэр хөрөнгийн өмчийн данс нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	5200.0	502,639.3	497,439.3
Бараа материал	9670.6	10,241.0	570.4
Үндсэн хөрөнгө	268,097.0	335,536.8	67,439.8
Нийт хөрөнгө	282,967.7	848,417.2	565,449.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	282,967.7	848,417.2	565,449.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	282,967.7	848,417.2	565,449.5

Авлагын дансны эхний үлдэгдэл 5,200.0 мянган төгрөг нь шинжлэх ухааны технологийн сангийн 2020 он хүртэл хэрэгжих 21-р зууны суралцагчийн цогц чадамжийн судалгааны томилолтын зардлын авлага хаагдсан байна.

Авлага дансны үлдэгдэл 502,639.3 мянган төгрөг болж, 497,439.3 мянган төгрөгөөр өссөн нь нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулаагүй үлдэгдлийн төвлөрүүлэх шилжүүлгийг буцаан авахаар авлагаар бүртгэснээс шалтгаалжээ. Авлагын дансны үлдэгдэл 500,592.1 мянган төгрөгийг төрийн сангийн мэргэжилтэнтэй, 2,047.2 мянган

төгрөгийг нийгмийн даатгалын байгууллагатай тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна. Авлага дансны үлдэгдэлд насжилт өндөртэй байхгүй байна

Бараа материалын данс нь төсвийн хөрөнгөөр 187,487.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 186,917.1 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, 10,241.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Бараа материалын дансны үлдэгдэлд насжилт өндөртэй, ашиглалтгүй, нөөц үүсгэн худалдан авсан бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 335,536.8 мянган төгрөг болж 67,439.8 мянган төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын А-1/1278 тоот албан бичгийн дагуу урсгал төсвийн худалдан авалтаар 21,809.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, БШУЯ-ны 2020 оны 2/1042 тоот албан бичгийн дагуу эрх шилжүүлсэн тендерээр үнэ төлбөргүй 83,375.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 13,570.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, ТӨБЗГ-ын 735 тоот тогтоолоор үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 19 нэр төрлийн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгасан 17,334.8 мянган төгрөг нийт 137,558.9 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн, тайлант жил тооцсон 70,119.1 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар буурсан, ТӨБЗГ-ын А-1/2327 тоот шийдвэрээр 85,639.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталснаас шалтгаалжээ.

Биет бус хөрөнгө урсгал төсвийн худалдан авалтаар ТӨБЗГ-ын А-1/1278 тоот албан бичгийн дагуу 1,470.0 мянган төгрөгийн программ хангамж худалдан авснаар нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 848,417.2 мянган төгрөг болж 565,449.5 мянган төгрөгөөр өссөн нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данснууд өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарснаас шалтгаалжээ.

Боловсролын хүрээлэнгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,832,650.1 мянган төгрөгөөр буюу 49.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, урсгал үйл ажиллагааны санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 1,241,376.3 мянган төгрөгөөр буюу 59.8 хувиар өсөж зардлын дансанд материаллаг өөрчлөлт гарсан.

Энэ нь Covid-19 цар тахлын өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор улсын хэмжээнд сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаа түр зогссоноос теле хичээл зохион байгуулах, сургалтын хөтөлбөр, хичээл практикийн зардал, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамран сургах зардал, цэцэрлэгийн хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад бататгах хичээлүүдийн агуулга, арга зүйн зөвлөмж боловсруулах орлого зарлага тусгагдсан тул орлого болон зардлын бүх данснуудад материаллаг өөрчлөлт гарсан болно.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,217,674.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,217,674.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 874,544.7 мянган төгрөгөөр бууруулж 1,343,129.8 мянган төгрөгөөр баталсан байна

Тус хүрээлэн нь ажиллагсдын орон тоог нэмэх, ном бүтээл хэвлүүлэх, эрдэм шинжилгээ, судалгаа хийх санал оруулсан боловч нэмээгүйгээс цалин, нийгмийн даатгалын зардал 304,144.2 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 15,943.7 мянга, хангамж, бараа материалын зардлыг 25,619.9 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 39,242.0 мянга, томилолт зочны зардлыг 18,442.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 471,152.7 мянга, нийт 874,544.7 мянган төгрөгийг бууруулж баталсан нь Covid-19 цар тахлын өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор тэвчиж болох зардал гэж үзсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,343,129.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,343,129.8 мянган төгрөгийг улсын төсвөөс 4,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,289,701.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 3,385.0 мянган төгрөг, нийт 1,293,086.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,272,857.4 мянган төгрөгийг зарцуулж 20,228.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,272,857.4 мянган төгрөг буюу 94.8 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,644.4 мянга, байр ашиглалттай холбоотой зардлыг 392.0 мянга, хангамж бараа материалын зардлыг 1,967.3 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 2,800.0 мянга, хичээл үйлдвэрлэл дадлагын зардлыг 4,499.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 53,863.5 мянга, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг 5,105.8 мянга, нийт 70,272.4 мянган төгрөгөөр тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хөтөлбөр арга хэмжээний төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь үндсэн үйл ажиллагааны зардал арга хэмжээ 12,303.0 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал арга хэмжээ 5,105.8 мянга, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн арга хэмжээ 52,863.5 мянган төгрөгөөр тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71805	Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага	1,343,129.8	1,272,857.3	(70,272.4)	94.7
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,030,552.8	1,018,249.7	(12,303.0)	98.8
1.2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	92,528.2	87,422.3	(5,105.9)	94.4
1.3	81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	220,048.8	167,185.3	(52,863.5)	75.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламж болон гадаад төсөл хөтөлбөрөөс 973,898.5 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 1,000,842.1 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 274,187.3 мянга, нийт 2,248,928.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин нийгмийн даатгалын зардалд 146,657.4 мянга, хангамж бараа материалын зардалд 37,790.6 мянга, норматив зардалд 21,972.8 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 17,529.0 мянга, албан томилолтын зардалд 2,273.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 824,830.9 мянга, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд 665,167.8 мянга, нийт 1,716,221.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 532,706.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 116 мэдээлэл, 35 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Шилэн дансанд байршуулсан мэдээллийг нягтлан бодох бүртгэлийн журналтай тулган шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн орлогын 1 удаагийн 14,463.3 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансанд байршуулаагүй;
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 34 шийдвэртэй холбоотой 22,593.7 мянган төгрөгийн тушаалын мэдээлэл болон хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой мэдээллийг байршуулаагүй;

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4,000.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт 85 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	4,000.0	1	3,385.0		615.0	85%
Нийт дүн	1	4,000.0	1	3,385.0		615.0	

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 63,718.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 17,334.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 219.4 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 37,055.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 9,109.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Тайлант онд ТӨБЗГ-ын 2020 оны 735 тоот зөвшөөрлийн дагуу үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 19 нэр төрлийн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгаж, үнийг 17,334.8 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож санхүүгийн тайланд тусгахдаа хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансанд бүртгэснийг УСНББОУС 17 Үндсэн хөрөнгө ба УСНББОУС 23 Арилжааны бус орлого стандартын 42, 44 дүгээр параграфын дагуу орлогоор хүлээн зөвшөөрч санхүүгийн тайланд тусгахдаа үнэ төлбөргүй орлогоор бүртгэж залрууллаа.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 219.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 219.4 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 37,055.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Байгууллагын нэр бүхий 2 ажилтанд үндсэн цалинг ээлжийн амралтын цалинтай давхардуулан 219.4 мянган төгрөг олгосон нь Хөдөлмөрийн тухай хууль, ЭМС нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаал, 79 дүгээр зүйл, 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 55 дугаар зүйлийн 55.1.2 дахь заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, үнэн зөв байдал, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

2. Байгууллагын шилэн дансны цахим сайтад нийт 151 мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 14,461.3 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй, мөн 699,884.9 мянган төгрөгийн 131 шийдвэрээс 22,593.7 мянган төгрөгийн 34 шийдвэрийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4. "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 6.4.5-д цалингийн зардлаас бусад таван саяаас дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 9,109.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

"Тогтвортой хөгжлийн төсөл-II" 2020-2022 онд хэрэгжих төслийн санхүүжилтын авлагын зарцуулалт, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Байгууллагын өөрийн үйл ажиллагааны онцлогийг тусгасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, өөрийн үйл ажиллагааны онцлогт нийцээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн удирдлага, зохион байгуулалт 18.2. “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг” баталж, мөрдөж ажиллах” гэж заасантай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

- Санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал, иж бүрэн байх батламж мэдэгдэл хангагдахгүй байх.
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчигдөх.

1.3. Өгсөн зөвлөмж

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан шинэчлэн боловсруулан мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2021 онд шинэчлэн боловсруулж байгаа болон зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах санал өгсөн.

2. Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт, үр дүнтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Үндсэн үйл ажиллагаанаас орох орлогын төлөвлөгөөг 4,000.0 мянган төгрөгөөр баталсан боловч төлөвлөгөө биелэгдээгүй өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж хэрэгжилт 85% -тай байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д хуулийн дагуу “улс орон нутгийн төсөвт оруулах тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх”-гэж заасантай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл:

- Санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал, иж бүрэн байх батламж мэдэгдэл хангагдахгүй байх.
- Төсвийн тухай хууль зөрчигдөх.

2.3. Өгсөн зөвлөмж

- Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д хуулийн заалтын дагуу орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авч ажиллана.

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Жолоочийн тооцооны замын хуудас бичсэн боловч автомашины 100 км-т зарцуулах нормативаар шатахууны тооцоог бодоогүй 7,062.6 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан нь ЗТХС-ын 2019 оны 390 дугаар тушаалын 7-р хавсралтаар батлагдсан автомашины шатахуун зарцуулалтын нормыг тооцох заавар, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/, 8 дугаар зүйлийн 8.1-т /Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө/, 13.7-т /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/-гэж заасантай нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл:

- Санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал, иж бүрэн байх батламж мэдэгдэл хангагдахгүй байх.
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчигдөх.

3.3. Өгсөн зөвлөмж:

- ЗТХС-ын 2019 оны 390 дугаар тушаалын 7-р хавсралт, 13 дугаар зүйлийн 13.1, 8 дугаар зүйлийн 8.1, 13.7 дахь заалтын дагуу жолоочийн замын хуудсаар шатахууны тооцоог бодож хэвших.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4. Дотоод хяналттай холбоотой асуудал:

4.1. Илрүүлэлт:

Цалингийн НДШ-ийг зөрүүтэй тооцоолж 2,047.1 мянган төгрөгийг илүү төлж авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5. /Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах/ заалтын дагуу төсвийг зохистой удирдаж өр төлбөр үүсгэхгүй ажиллах” гэж заасантай нийцэхгүй байна.

4.2. Эрсдэл:

- Санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал, иж бүрэн байх батламж мэдэгдэл хангагдахгүй байх.
- Нягтлан бодох бүртгэлийн, Нийгмийн даатгалын тухай хууль зөрчигдөх.

4.3 Өгсөн зөвлөмж

- Төсвийн тухай хуулийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 дахь заалтын дагуу төсвийг зохистой удирдаж өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.20	Аудитын нэр: Боловсролын хүрээлэнгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/98./СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Боловсролын хүрээлэн	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Байгууллагын өөрийн үйл ажиллагааны онцлогийг тусгасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомжид нийцээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйл.Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн удирдлага, зохион байгуулалт 18.2. “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.” гэж заасныг зөрчиж байна	0	Зөвлөмж өгөх	Захирал, Нягтлан бодогч	П.Лхагвасүрэн Б.Цэрэнханд
2	Үндсэн үйл ажиллагаанаас орох орлогын төлөвлөгөөг 4,000.0 мянган төгрөгөөр баталсан боловч төлөвлөгөө биелэгдээгүй өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж хэрэгжилт 85% байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д хуулийн дагуу улс орон нутгийн төсөвт оруулах тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг зөрчиж байна.	0	Зөвлөмж өгөх	Захирал, Нягтлан бодогч	П.Лхагвасүрэн Б.Цэрэнханд
3	Жолоочийн тооцооны замын хуудас бичсэн боловч автомашины 100 км-т зарцуулах нормативаар жолоочийн шатахууны тооцоог бодоогүй 7,062.6 мянган төгрөгийн шатахууны зарцуулсан нь ЗТХС-ын 2019 оны 390 дугаар тушаалын 7-р хавсралтаар батлагдсан автомашины шатахуун зарцуулалтын нормыг тооцох заавар, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/, 8 дугаар зүйлийн 8.1-т /Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө/, 13.7-т /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/ гэж заасныг зөрчиж байна.	7,062.6	Зөвлөмж өгөх	Захирал, Нягтлан бодогч	П.Лхагвасүрэн Б.Цэрэнханд

4	Цалингийн НДШ-ийг зөрүүтэй тооцоолж 2,047.1 мянган төгрөгийг илүү төлж авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5. /Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах/-гэж заасныг зөрчиж байна.	2,047.1	Зөвлөмж өгөх	Захирал, Нягтлан бодогч	П.Лхагвасүрэн Б.Цэрэнханд
5	Байгууллагын шилэн дансны цахим сайтад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 14,461.3 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй, мөн 699,884.9 мянган төгрөгийн 131 шийдвэрээс 22,593.7 мянган төгрөгийн 34 шийдвэрийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 -д /Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр/ Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй/ гэж заасныг заасныг зөрчиж байна.	37,055.0	Албан шаардлага өгөх	Захирал, Нягтлан бодогч	П.Лхагвасүрэн Б.Цэрэнханд
6	Байгууллагын нэр бүхий ажилтанд үндсэн цалинг ээлжийн амралтын цалинтай давхардуулан 219,4 мянган төгрөгийн цалин олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1. /Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд мөнгөн урамшуулал олгож болно. Мөнгөн урамшуулал олгох журмыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцсоны үндсэн дээр ажил олгогчийн шийдвэрээр зохицуулна/ Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт /ажил олгогч нь бүх ажилтан жил бүр ээлжийн амралтаа заавал биеэр эдлүүлэх бололцоогоор хангаж эдлүүлнэ /-ыг, Хөдөлмөрийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.2 дахь заалт/ ажилтанд ээлжийн амралтын хугацаанд нь ээлжийн амралтын олговор олгоно/ гэж заасныг зөрчиж байна.	219.4	Төлбөрийн акт тогтоох	Захирал, Нягтлан бодогч	П.Лхагвасүрэн Б.Цэрэнханд
ДҮН		46,384.1			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 57/А0160058

Улаанбаатар хот

САГ-2021/98/СТА-743

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Боловсролын хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын нэр бүхий 2 ажилтанд үндсэн цалин, ээлжийн амралтыг давхардуулан 219,842 /хоёр зуун арван есөн мянга найман зуун дөчин хоёр/ төгрөгийг олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-д “Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд мөнгөн урамшуулал олгож болно. Мөнгөн урамшуулал олгох журмыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцсоны үндсэн дээр ажил олгогчийн шийдвэрээр зохицуулна”, Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалын 1 дүгээр зүйлийн 1.3-т “ажил олгогч нь бүх ажилтныг жил бүр ээлжийн амралтаа заавал биеэр эдлүүлэх бололцоогоор хангаж эдлүүлнэ”, Хөдөлмөрийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.2-т “ажилтанд ээлжийн амралтын хугацаанд нь ээлжийн амралтын олговор олгоно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ажилтанд үндсэн цалинг ээлжийн амралтын цалинтай давхардуулан олгосон 219,842 /хоёр зуун арван есөн мянга найман зуун дөчин хоёр/ төгрөгийг буруутай этгээдээр төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсролын хүрээлэнгийн захирал П.Лхагвасүрэн, ерөнхий нягтлан бодогч Б.Цэрэнханд нарт даалгав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР,
АХЛАХ АУДИТОР,
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ
“ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ” ХХК -ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Г.ЦЭЦЭГМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 212/АО160058

Улаанбаатар хот

СТА-2021/98/СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Боловсролын хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансны цахим сайтад байршуулах нийт 151 мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 14,461.300 /Арван дөрвөн сая дөрвөн зуун жаран нэгэн мянга гурван зуун/ төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй, мөн 699,884.900 / зургаан зуун ерэн есөн сая найман зуун наян дөрвөн мянга есөн зуун/ төгрөгийн 131 шийдвэрээс 22,593.7 00 /хорин хоёр сая таван зуун ерэн гурван мянга долоон зуун/ төгрөгийн 34 шийдвэрийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4. "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 6.4.5-д цалингийн зардлаас бусад таван саяас дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасныг тус тус зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө". Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 -д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын хүрээлэнгийн захирал П.Лхагвасүрэн, ерөнхий нягтлан бодогч Б.Цэрэнханд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР,
АХЛАХ АУДИТОР,
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ
"ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ" ХХК
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Г.ЦЭЦЭГМАА

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing the conclusion.